

2019 оны I улирал

# НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2019  
оны I улирлын санхүүгийн тайлангийн  
нэгтгэлийн танилцуулга

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	7
Зургийн жагсаалт.....	7
1. Салбарын өнөөгийн байдал .....	1
1.1 Ерөнхий төлөв байдал.....	1
Үйл ажиллагааны төрөл.....	1
1.2 Статистик үзүүлэлтүүд .....	2
Харилцагчид.....	2
Хувьцаа эзэмшигчид .....	2
Ажиллагсад .....	2
Програм ашиглалт .....	3
Тархалт .....	3
2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа.....	5
2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт .....	5
Мөнгөн хөрөнгө.....	5
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	6
Факторингийн тооцооны авлага, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, бусад хөрөнгө, санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага, эргэлтийн бус хөрөнгө .....	6
2.2 Зээл.....	7
Зээлийн зориулалт .....	7
Зээлийн багцын чанар .....	7
Зээлдэгчид.....	8
Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	9
3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт .....	10
3.1 Өр төлбөр.....	10
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	10
Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг .....	11
Бусад эх үүсвэр .....	11
ББСБ-аас гаргасан өрийн бичиг .....	11
Төслийн зээл санхүүжилт .....	11
Бусад өр төлбөр .....	12
3.2 Эздийн өмч.....	12
4. Орлого, үр дүнгийн тайлан.....	14
4.1 Орлого.....	14

Хүүгийн орлого.....	14
Хүүгийн бус орлого.....	14
Үндсэн бус үйл ажиллагааны орлого .....	15
4.2 Зарлага .....	15
Хүүгийн зардал.....	15
Хүүгийн бус зардал .....	15
Болзошгүй эрсдэлийн зардал.....	15
Үндсэн бус үйл ажиллагааны зардал.....	15
4.3 Ашигт ажиллагаа .....	15
<b>5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....</b>	<b>16</b>
Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	16
Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	17
Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	17
<b>6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....</b>	<b>19</b>
6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд .....	19
Ерөнхий статистик .....	19
Актив.....	19
Пассив.....	20
Орлого үр дүнгийн тайлан.....	20
6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд.....	20
Ерөнхий статистик .....	20
Актив.....	21
Пассив.....	21
Орлого үр дүнгийн тайлан.....	21
6.3 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд.....	21
Ерөнхий статистик .....	21
Актив.....	21
Пассив.....	22
Орлого үр дүнгийн тайлан.....	22
Гадаад валютын арилжааны дүн мэдээ .....	22
<b>ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ .....</b>	<b>23</b>
<b>ДҮГНЭЛТ.....</b>	<b>23</b>

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл.....	1
Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо.....	1
Хүснэгт 5 Харилцагчид 2019-I .....	2
Хүснэгт 6 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/ .....	2
Хүснэгт 7 ББСБ-уудын тархалт /хот/ .....	3
Хүснэгт 8 Активын бүтэц /сая төгрөгөөр/.....	5
Хүснэгт 9 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/ .....	5
Хүснэгт 11 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/ .....	6
Хүснэгт 12 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/ .....	7
Хүснэгт 13 Ерөнхий статистик /харилцагчид/ .....	8
Хүснэгт 14 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/ .....	10
Хүснэгт 15 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/ .....	11
Хүснэгт 16 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/.....	11
Хүснэгт 18 Бусад пассив /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 19 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/ .....	13
Хүснэгт 20 Санхүүгийн үйлчилгээний орлого /мянган төгрөгөөр/.....	15
Хүснэгт 21 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 22 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ.....	16
Хүснэгт 23 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ.....	17
Хүснэгт 24 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ.....	18
Хүснэгт 25 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл.....	19
Хүснэгт 26 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц .....	20
Хүснэгт 27 Орон нутгийн ББСБ-уудын пассивын бүтэц.....	20
Хүснэгт 28 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл .....	20
Хүснэгт 29 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив .....	21
Хүснэгт 30 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/.....	21
Хүснэгт 31 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /мянган төгрөгөөр/.....	22
Хүснэгт 32 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн мэдээ /2019-I улирал/.....	22

## Зургийн жагсаалт

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо.....	1
Зураг 2 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо .....	2
Зураг 3 Санхүүгийн програм ашиглалт.....	3
Зураг 4 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт.....	3
Зураг 5 Мөнгөн хөрөнгө /сүүлийн 5 жилээр/.....	6
Зураг 6 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /2019 оны I улирал/.....	6
Зураг 7 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/ .....	6
Зураг 8 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/ .....	7
Зураг 9 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/.....	7
Зураг 10 Зээлийн ангилал /хувиар/ .....	8
Зураг 11 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа .....	8
Зураг 12 Зээлдэгчдийн боловсрол .....	8
Зураг 13 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	9
Зураг 14 Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	10


Зураг 15 Бусад эх үүсвэрийн бүтэц .....	11
Зураг 16 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/ .....	12
Зураг 17 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг.....	12
Зураг 18 Пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	12
Зураг 19 Ашигт ажиллагааны үзүүлэлт.....	14
Зураг 20 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	14
Зураг 21 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/.....	14
Зураг 22 Үндсэн бус үйл ажиллагааны орлого .....	15
Зураг 23 Ашгийн өсөлт /хувиар/ .....	16
Зураг 24 Зохистой харьцаа .....	16
Зураг 25 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт .....	19
Зураг 26 Орон нутгийн ББСБ-уудын чанаргүй зээлийн бүтэц .....	20

## 1. Салбарын өнөөгийн байдал

### 1.1 Ерөнхий төлөв байдал

2019 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 ББСБ буюу 0.4 хувиар өсөж 539 ББСБ-д хүрчээ.

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



2019 оны I улирлын байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ байгаа бол хөдөө орон нутагт 77 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

	2015-I	2016-I	2017-I	2018-I	2019-I
Шинээр олгосон	18	15	13	5	3
Хүчингүй	1	2	2	2	3
Түдгэлзүүлсэн	2	0	17	1	4
Сэргээсэн	0	0	0	1	4
<b>Нийт ББСБ</b>	<b>395</b>	<b>463</b>	<b>529</b>	<b>537</b>	<b>539</b>

2019 оны I улиралд банк бус санхүүгийн салбартай холбоотой Хорооны даргын 176 тушаал гарчээ. Үүнээс 154 тушаалаар 152 ББСБ /2 ББСБ 2 удаа өөрчлөлт оруулсан/ 91.2 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж, 4 ББСБ оноосон нэрээ өөрчилсөн бол 4 ББСБ 5 салбар нээж, 3 ББСБ-ын 15 салбар хаах асуудлыг шийдвэрлэсэн байна.

### Үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2019 оны I улирлын байдлаар 539 ББСБ 9 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 787 үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 91.5% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 351 ББСБ буюу 65.1% нь дагнан эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 28.8% нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 44 ББСБ буюу 8.2% дагнан эрхэлж байна.

Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өсөлт	
		2018-I	2019-I	тоо	хувь
	Нийт ББСБ	537	539	2	0.4%
1	Зээл	486	493	7	1.4%
	<i>Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	353	351	-2	-0.6%
2	Факторингийн үйлчилгээ	21	23	2	9.5%
3	Төлбөрийн баталгаа гаргах	17	18	1	5.9%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2	3	1	50.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	18	24	6	33.3%
6	Гадаад валютын арилжаа	148	155	7	4.7%
	<i>Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	51	44	-7	-13.7%
7	Итгэлцлийн үйлчилгээ	28	31	3	10.7%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	8	9	1	12.5%
	<i>Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх</i>	32	31	-1	-3.1%

2019 оны I улиралд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан ББСБ-уудын хувьд зээлийн үйл ажиллагааны 3, гадаад валютын арилжааны 1 тусгай зөвшөөрөл авсан бөгөөд, үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудаас факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл 1 ББСБ, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл 2 ББСБ


нэмж авчээ. Мөн зээлийн 2, гадаад валют арилжааны 3, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээний 1 тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон байна.

## 1.2 Статистик үзүүлэлтүүд

2019 оны I улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 539 ББСБ-аас 96.5% буюу 520 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд дор дурдсан нэр бүхий 19 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан байна.

2019 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 7207 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ 220 салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2820 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,664,902 харилцагчдад хүрч үйлчилж байна.

Зураг 2 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо



### Харилцагчид

Нийт харилцагчдын 49.8% нь эмэгтэй, 50.0% нь эрэгтэй, 0.2% нь хуулийн этгээд байна. 90.7 хувийг 3 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна.

Хүснэгт 3 Харилцагчид 2019-I

	ББСБ тоо	Хувь	Харилцагчдийн тоо	Хувь
100-аас доош	362	67.2%	12,508	0.8%
100-1000	141	26.2%	37,082	2.7%
1001-10,000	31	5.8%	83,695	7.1%
10,000-1,000,000	4	0.7%	185,953	15.6%
1,000,000-аас дээш	1	0.2%	1,345,664	73.9%
<b>НИЙТ</b>	<b>539</b>	<b>100.0%</b>	<b>1,664,902.00</b>	<b>100.0%</b>

### Хувьцаа эзэмшигчид

2019 оны I улирлын байдлаар 539 ББСБ-ын 7207 хувьцаа эзэмшигч байна. ББСБ-ууд компанийн тодорхой хувийг нийтэд санал болгож хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болсонтой холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн тоо 1.3 дахин өсжээ. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийг оролцуулалгүйгээр 1049 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байгаа ба энэ нь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өссөн үзүүлэлт юм.

Нийт 539 ББСБ-ын 298 нь 1 хувьцаа эзэмшигчтэй байгаа бол 241 нь 2 ба түүнээс дээш тооны хувь нийлүүлэгчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

### Ажиллагсад

539 ББСБ-д 2820 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.3 хувь буюу 309 ажилтнаар оны эхнээс 1.3 хувь буюу 36 ажилтнаар нэмэгдсэн дүн юм. Нийт ажилчдын 79.0% буюу 1575 нь эмэгтэй, 21.0% буюу 1245 нь эрэгтэй ажилчид байна.

2019 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.4 их наяд төгрөг байгаа нь банкны салбарын 4.2%-тай тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад актив 348.7 тэрбум төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн байна. Активын өсөлтийн 77.1 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 53.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 4 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/


Үзүүлэлтүүд	2018-I	2018-IV	2019-I
Нийт хөрөнгө	1,046.8	1,284.9	1,395.5
Банкны салбартай харьцуулахад хувиар	3.6%	3.9%	4.2%
Нийт өөрийн хөрөнгө	811.3	977.4	1,061.4
Банкны салбартай харьцуулахад хувиар	25.6%	30.0%	31.7%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	645.5	740.6	832.4
Банкны салбартай харьцуулахад хувиар	97.1%	83.8%	90.7%
Нийт зээл	706.7	869.2	975.5
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.0%	5.1%	5.6%
Нийт орлого	56.8	259.5	75.4
Нийт зарлага	38.5	158.4	44.4
Цэвэр ашиг	18.2	101.1	31.0

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 32.7 хувиар буюу 18.6 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 10.3 хувиар буюу 5.9 тэрбум төгрөгөөр, цэвэр ашигийн хэмжээ 69.9 хувиар буюу 12.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

### Програм ашиглалт

2019 оны I улирлын байдлаар 539 ББСБ-ын 345 нь буюу 64.0% нь санхүүгийн програмтай үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 462 ББСБ-ын 310 нь буюу 67.1%, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 77 ББСБ-ын 45.5% нь санхүүгийн програмтай байна.

Зураг 3 Санхүүгийн програм ашиглалт




### Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.7% буюу 462 ББСБ, салбаруудын

69.1% буюу 152 салбар байршиж байна. Үүний 66.7% буюу 308 ББСБ Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Багануур дүүрэгт 1 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 4 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт



Нийт 4 ББСБ-ын 5 төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаа ба Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Баянгол дүүрэг, Булган аймгийн Булган сум болон Америкийн Нэгдсэн улсын Вашингтон хотод тус тус байршиж байна.

Хүснэгт 5 ББСБ-уудын тархалт /хот/

Дүүрэг	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Сүхбаатар	161	20	181	29.5%
Чингэлтэй	147	24	171	27.9%
Баянгол	67	41	108	17.6%
Баянзүрх	51	29	80	13.0%
Хан-Уул	28	14	42	6.8%
Сонгинохайрхан	7	18	25	4.1%
Багануур	1	4	5	0.8%
Налайх	0	2	2	0.3%
Багахангай	0	0	0	0.0%
<b>НИЙТ /хот/</b>	<b>462</b>	<b>152</b>	<b>614</b>	<b>100.0%</b>

Хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 14.3% буюу 77 ББСБ, салбаруудын 30.9% буюу 68 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Нийт 67 ББСБ-ын 220 салбар бүртгэлтэй байгаа ба үүний 32.3 хувийг 4 ББСБ-ын 71 салбар бүрдүүлж байгаа бол 6-9 салбартай 6 ББСБ, 2-5 салбартай 25 ББСБ, 1 салбартай 32 ББСБ Улаанбаатар хотын 8



дүүрэг, Монгол улсын 18 аймагт үйл  
ажиллагаа явуулж байна.

## 2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа

### 2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт

2019 оны I улиралд ББСБ-уудын актив 1.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 33.3% буюу 348.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 6 Активын бүтэц /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2018-I дүн	2018-IV дүн	2019-I дүн	Өөрчлөлт			
				Өмнөх оны мөн үе		Оны эхэн	
				дүн	хувь	дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,008,583.3	1,234,705.7	1,344,050.1	335,466.9	33.3%	109,344.4	8.9%
Мөнгөн хөрөнгө	264,171.0	315,113.9	315,791.7	51,620.7	19.5%	677.8	0.2%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,774.0	1,837.5	1,828.5	54.5	3.1%	-9.0	-0.5%
Зээл (цэврээр)	647,868.9	804,745.6	907,130.3	259,261.3	40.0%	102,384.7	12.7%
Нийт зээл	706,745.5	869,222.4	975,538.4	268,793.0	38.0%	106,316.0	12.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	58,876.6	64,476.9	68,408.2	9,531.6	16.2%	3,931.3	6.1%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	125.0	7,292.9	5,742.8	5,617.8	44.9 дахин	-1,550.1	-21.3%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	8,878.1	10,223.0	10,184.3	1,306.2	14.7%	-38.7	-0.4%
Бусад хөрөнгө	85,766.3	95,492.8	103,372.6	17,606.3	20.5%	7,879.7	8.3%
Эргэлтийн бус хөрөнгө	38,188.9	50,191.7	51,436.9	13,248.0	34.7%	1,245.2	2.5%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	38,188.9	50,191.7	51,436.9	13,248.0	34.7%	1,245.2	2.5%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,046,772.2</b>	<b>1,284,897.4</b>	<b>1,395,487.0</b>	<b>348,714.8</b>	<b>33.3%</b>	<b>110,589.6</b>	<b>8.6%</b>

Салбарын нийт активын 96.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгө оны эхнээс 8.6% буюу 110.6 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 33.3% буюу 348.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт активын 87.6% буюу 1,222.9 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө болон цэвр зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Активын гол өөрчлөлтүүдийг харвал цэвр зээлийн үлдэгдэл 40.0% буюу 259.3 тэрбум төгрөгөөр, мөнгөн хөрөнгө 19.5% буюу 51.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 1.4 тэрбумаас дээш хөрөнгөтэй 313 ББСБ нийт активын 88.7 хувийг, 1.0-1.4 тэрбум хүртэл хөрөнгөтэй 106 ББСБ нийт активын 8.7 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 119 ББСБ нийт активын 2.6 хувийг эзэлж байна.


Хүснэгт 7 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/

Интервал	ББСБ тоо	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
1.0 тэрбумаас доош	119	22.1%	35.9	2.6%
1.0-1.4 тэрбум хүртэл	106	19.7%	121.3	8.7%
1.4-4.9 тэрбум хүртэл	270	50.1%	575.7	41.2%
5 тэрбум ба түүнээс дээш	44	8.2%	662.6	47.5%
<b>НИЙТ</b>	<b>539</b>	<b>100%</b>	<b>1,395.5</b>	<b>100.0%</b>

#### Мөнгөн хөрөнгө

Нийт активын 22.6% буюу 315.8 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Мөнгөн хөрөнгийн 170.6 тэрбум төгрөг буюу 54.0% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 93.1 тэрбум буюу 29.5% нь банк болон санхүүгийн байгууллагын харилцах дансанд, 52.1 тэрбум буюу 16.5% нь хадгаламжид байршиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэлэн мөнгө 17.8 хувиар, хадгаламж 6.5 хувиар, харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө 27.4 хувиар өссөн байна.

Зураг 5 Мөнгөн хөрөнгө /сүүлийн 5 жилээр/




### Богино хугацаат хөрөнгө оруулалт

2019 оны I улирлын байдлаар богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.1 хувийг бүрдүүлж байна. 20 ББСБ 1.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Цэвэр богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн оны эхнээс 0.5% буюу 9.0 сая төгрөгөөр буурсан бол өмнөх оны мөн үеэс 3.1% буюу 54.5 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарчээ.

Арилжааны үнэт цаасанд 95.2% буюу 1,740.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 4.8% буюу 88.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Зураг 6 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /2019 оны I улирал/



Богино хугацаат хөрөнгө оруулалтын 96.8 хувийг хувьцаагаар, 2.9 хувийг Засгийн газрын бондоор, 0.3 хувийг бусад хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.


Факторингийн тооцооны авлага, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, бусад хөрөнгө, санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага, эргэлтийн бус хөрөнгө

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 44.9 дахин нэмэгдсэн ба тусгай зөвшөөрөлтэй 23 ББСБ-аас 3 ББСБ-ын 5.7 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны авлага бүртгэгдсэн байна.

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум төгрөгөөр өсөж 11.0 тэрбум төгрөгт, өмчлөх бусад хөрөнгө 1.0 тэрбум төгрөгөөр буурч 1.4 тэрбум төгрөгт хүрч тэдгээрт нийт 5.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Бусад хөрөнгө өмнөх оны мөн үеэс 19.0% буюу 16.3 тэрбум төгрөгөөр өсөж 102.0 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 7.3 хувийг бүрдүүлж байна. 2019 оны I улирлын байдлаар бусад хөрөнгийн 53.7 хувийг хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 20.7 хувийг цэвэр авлага, 25.7 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Зураг 7 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 539 ББСБ-ын 63.6 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд 12.2 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 8 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2018-I	2019-I	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Үндсэн ба биет бус хөрөнгө	47.3	63.7	16.4	34.6%
Барилга байгууламж	16.4	21.9	5.5	33.8%

Техник хэрэгсэл	17	24.2	7.2	42.1%
Тавилга эд хогшил	6	7.7	1.7	28.1%
Дуусаагүй барилга	3.6	5.2	1.6	43.2%
Биет бус хөрөнгө	4.2	4.7	0.5	12.2%
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	<b>-9.1</b>	<b>(12.2)</b>	<b>(3.1)</b>	<b>34.2%</b>
Барилга байгууламжийн	1.2	1.7	0.5	42.3%
Техник хэрэгслийн	5.7	7.8	2.1	37.1%
Тавилга эд хогшлын	2.2	2.7	0.5	22.4%
<b>ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)</b>	<b>38.2</b>	<b>51.4</b>	<b>13.2</b>	<b>34.7%</b>


## 2.2 Зээл

2019 оны I улирлын байдлаар 477 ББСБ нь 975.5 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй, 263,949 зээлдэгчид зээлийн үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь нийт активын 69.9%, эргэлтийн хөрөнгийн 72.6 хувийг бүрдүүлж байна.

### Зээлийн зориулалт

2018 оны жилийн эцсийн байдлаар 470 ББСБ-ын 706.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан бол 2019 оны I улирлын байдлаар 408 ББСБ 431.9 тэрбум төгрөгийн зээл олгож, 429 ББСБ-ын 323.8 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 477 ББСБ-ын 975.5 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлд 68.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж 475 ББСБ 907.1 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарчээ.


Зураг 8 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/



Олгосон зээлийн 89.7% буюу 387.5 тэрбум төгрөгийг иргэдэд олгосон бол

10.3% буюу 44.4 тэрбум төгрөгийг хуулийн этгээдэд олгосон байна.

Зураг 9 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/



Олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл, хэрэглээний зээлд 284.7 тэрбум төгрөгийн зээл олгож, 210.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн бол худалдааны салбарт 56.3 тэрбум төгрөгийн зээл олгож, 48.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгджээ.

Өмнөх оны мөн үеэс хэвийн зээл 43.3 хувиар буюу 255.7 тэрбум төгрөгөөр, хугацаа хэтэрсэн зээл 6.0 хувь буюу 2.3 тэрбум төгрөгөөр, чанаргүй зээлийн хэмжээ 13.9 хувиар буюу 10.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

### Зээлийн багцын чанар


Хүснэгт 9 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн чанарын ангилал	2018-I дүн	2019-I дүн	Өөрчлөлт	
			хувь	хувь
Хэвийн	590.5	846.2	255.7	43.3%
Хугацаа хэтэрсэн	37.9	40.2	2.3	6.0%
Чанаргүй:	78.3	89.1	10.8	13.9%
Хэвийн бус	17.1	19.6	2.5	14.4%
Эргэлзээтэй	16.5	18.2	1.7	10.2%
Муу	44.8	51.4	6.6	14.8%
(Зээлийн эрсдэлийн сан)	-58.9	-68.4	127.3	-216.1%
<b>Нийт зээл</b>	<b>706.7</b>	<b>975.5</b>	<b>268.8</b>	<b>38.0%</b>
Зээл (цэврээр)	647.9	907.1	259.2	40.0%
Нийт зээл (төгрөгийн)	669	943.4	274.4	41.0%

Нийт (валютын)	зээл	37.8	32.2	(5.6)	-14.9%
-------------------	------	------	------	-------	--------


Нийт зээлийн 846.2 тэрбум төгрөг буюу 86.7 хувийг хэвийн зээл, 40.2 тэрбум төгрөг буюу 4.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 10.8 тэрбум төгрөг буюу 9.1 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдлийн 52.9 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна.

Зураг 10 Зээлийн ангилал /хувиар/



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хугацаа хэтэрсэн зээл 1.3 пунктээр, чанаргүй зээлийн хэмжээ 1.9 пунктээр буурч, хэвийн зээлийн хэмжээ 3.2 пунктээр өссөн үзүүлэлттэй гарчээ.

Зураг 11 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа



Нийт зээлийн эцсийн үлдэгдэлд эзлэх валютын зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.0 пунктээр буурсан

бол төгрөгийн зээлийн хэмжээ 2.0 пунктээр өссөн дүнтэй гарчээ.

### Зээлдэгчид


Хүснэгт 10 Ерөнхий статистик /харилцагчид/

Харилцагчдын мэдээлэл	Дүн	Хувь
Нийт харилцагчдын тоо	1,644,228	100.0%
Үүнээс: Эмэгтэй	829,030	50.4%
Хуулийн этгээд	2,509	0.2%
Зээлдэгчдийн тоо	263,949	100.0%
Хэвийн	239,705	90.8%
Хугацаа хэтэрсэн	14,421	5.5%
Чанаргүй:	9,823	3.7%
Хэвийн бус	3,273	1.2%
Эргэлзээтэй	2,834	1.1%
Муу	3,716	1.4%
Зээлдэгчдийн насжилт	262,057	100.0%
18-35 насны	145,862	55.7%
36-45 насны	69,043	26.3%
46-55 насны	34,339	13.1%
55-аас дээш	12,813	4.9%
Зээлдэгчдийн боловсрол	262,057	100.0%
-Дээд	157,600	60.1%
-Тусгай дунд	16,946	6.5%
-Бүрэн дунд	79,848	30.5%
-Дунд	6,816	2.6%
-Бага	847	0.3%

2019 оны I улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 493 ББСБ-ын 263,949 зээлдэгч бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрийн 90.8% буюу 239,705 нь хэвийн, 5.5% буюу 14,421 хугацаа хэтэрсэн, 1.2% буюу 3,273 нь хэвийн бус, 1.1% буюу 2,834 нь эргэлзээтэй, 1.4% буюу 3,716 муу зээлдэгчид байна.

Насжилтын хувьд авч үзвэл нийт зээлдэгчдийн 82.0% буюу 214,905 нь 18-45 насны, 13.1% буюу 34,339 нь 46-55 насны, 4.9% буюу 12,813 нь 55-аас дээш насны иргэд байна.

Зураг 12 Зээлдэгчдийн боловсрол




Боловсролын түвшнээр дээд болон тусгай дунд боловсролтой иргэд нийт

зээлдэгчдийн 157,600 буюу 66.6 хувийг бүрдүүлж байгаа бол бүрэн дунд боловсролтой иргэд 79,848 буюу 30.5 хувийг, бага болон дунд боловсролтой иргэд 7,663 буюу 2.9 хувийг бүрдүүлж байна.

### Зээлийн жигнэсэн дундаж хүү

2019 оны I улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 493 ББСБ-аас 298 ББСБ 431.9 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 3.4% байна.

Зураг 13 Зээлийн жигнэсэн дундаж хүү



ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.4%-тай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй байна. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 2.0 пунктээр өндөр гарсан байна.

### 3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт хөрөнгийн 23.9% буюу 334.1 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 76.1% буюу 1,061.4 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. Харин өр төлбөрийн 44.5% буюу 148.5 тэрбум төгрөгийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, 19.8% буюу 66.1 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээний өглөг эзэлж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн 78.4 % буюу 832.4 тэрбум төгрөгийг хувьцаат капитал, 19.9% буюу 211.4 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг эзэлж байна.

2019 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 11 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/

Хөрөнгө	2018-I	2018-IV	2019-I	Өөрчлөлт			
				Оны эхнээс		Өмнөх оны мөн үеэс	
				Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
Өр төлбөр	235,455.1	307,453.8	334,072.3	26,618.5	8.7%	98,617.2	41.9%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	42,229.0	57,607.1	66,059.6	8,452.5	14.7%	23,830.6	56.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	126,821.3	151,009.6	148,497.2	-2,512.4	-1.7%	21,675.9	17.1%
Бусад эх үүсвэр	9,603.8	15,668.3	14,373.9	-1,294.4	-8.3%	4,770.1	49.7%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	9,914.0	23,477.8	29,415.8	5,938.0	25.3%	19,501.8	196.7%
Төслийн зээлийн санхүүжилт	16,446.1	17,848.8	18,111.0	262.2	1.5%	1,664.9	10.1%
Бусад өр төлбөр	30,441.0	41,842.2	57,614.8	15,772.6	37.7%	27,173.8	89.3%
Эздийн өмч	811,317.1	977,443.6	1,061,414.7	83,971.1	8.6%	250,097.6	30.8%
Хувьцаат капитал	645,504.3	740,759.0	832,359.0	91,600.0	12.4%	186,854.7	28.9%
Бусад өмч	10,145.9	10,598.7	16,187.8	5,589.1	52.7%	6,041.9	59.6%
Сангууд	463.5	532.7	653.6	120.9	22.7%	190.1	41.0%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	154,536.8	224,586.5	211,377.7	-13,208.8	-5.9%	56,840.9	36.8%
Хоёрдогч өглөг	666.6	966.6	836.6	-130.0	-13.5%	170.0	25.5%
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>1,046,772.2</b>	<b>1,284,897.4</b>	<b>1,395,487.0</b>	<b>110,589.6</b>	<b>8.6%</b>	<b>348,714.8</b>	<b>33.3%</b>

#### 3.1 Өр төлбөр


ББСБ-ын өр төлбөрийн хэмжээ 2019 оны I улиралд өмнөх оны мөн үеэс 98.6 тэрбум төгрөгөөр буюу 41.9 хувиар, оны эхнээс 26.6 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар өсөж нийт пассивын 23.9% буюу 334.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

#### Итгэлцлийн үйлчилгээний өглөг

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 31 ББСБ-ын 27 нь 2019 оны I улирлын байдлаар 66.1 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт пассивын 4.7 хувьтай тэнцэж байна. Энэ нь өмнөх

оны мөн үеэс 56.4 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 14 Итгэлцлийн үйлчилгээний өглөг



төвлөрүүлсэн 66.1 тэрбум төгрөгийн 82.1% буюу 54.2 тэрбум төгрөгийг 26 ББСБ төгрөгөөр, 17.9% буюу 11.8 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 10 ББСБ валютаар татан төвлөрүүлсэн байна.

### Дотоод гададын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2019 оны I улирлын байдлаар 76 ББСБ дотоод гададын банк, санхүүгийн байгууллагаас татсан 148.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт хөрөнгийн 10.6 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 21.7 тэрбум төгрөгөөр буюу 17.1 хувиар өссөн, оны эхнээс 2.5 тэрбум төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан үзүүлэлт юм.

Банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн 73.9 хувийг дотоодын, 26.1 хувийг гададын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл эзэлж байна. Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас 75 ББСБ 109.7 тэрбум төгрөг, гададын банк санхүүгийн байгууллагуудаас 5 ББСБ 38.7 тэрбум төгрөгийн зээл татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 12 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

Авсан зээлийн хэмжээ	ББСБ-ын тоо	Зээлийн хэмжээ	Нийт зээлд эзлэх хувь
1 тэрбумаас дээш	19	93.1	84.9%
0.1-0.9 тэрбум	45	16.1	14.7%
0.1 тэрбумаас доош	11	0.5	0.5%
<b>НИЙТ</b>	<b>75</b>	<b>109.7</b>	<b>100.0%</b>

Хүснэгт 13 Гададын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/


Авсан зээлийн хэмжээ	ББСБ тоо	Зээлийн хэмжээ	Нийт зээлд эзлэх хувь
10 тэрбумаас дээш	1	27.4	70.6%
1-9 тэрбум	2	9.9	25.5%
1 тэрбумаас доош	2	1.5	3.9%
<b>НИЙТ</b>	<b>5</b>	<b>38.8</b>	<b>100.0%</b>

### Бусад эх үүсвэр

Бусад эх үүсвэр нийт пассивын 1.0% буюу 14.4 тэрбум төгрөгийг бүрдүүлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 49.7% буюу 4.7 тэрбум төгрөгөөр өссөн, оны эхнээс 8.3% буюу 1.3 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй гарчээ.

2019 оны I улирлын байдлаар бусад эх үүсвэрийн 17.7% буюу 2.5 тэрбум төгрөгийг 7 ББСБ-ын цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг, 25.7% буюу 3.7 тэрбум төгрөгийг 1 ББСБ-ын төлбөр тооцооны үйлчилгээний өглөг, 56.6% буюу 8.1 тэрбум төгрөгийг 2 ББСБ факторингийн үйлчилгээний өглөг байна. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 24 ББСБ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрөлтэй 3 ББСБ, факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 23 ББСБ байна.

Зураг 15 Бусад эх үүсвэрийн бүтэц



### ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2019 оны I улирлын байдлаар 25 ББСБ өрийн бичгээр 29.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Үүний 28,756.8 сая төгрөгийг төгрөгөөр, 659.0 сая төгрөгийг валютаар татан төвлөрүүлсэн байна.

Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.0 дахин буюу 19.5 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 25.3% буюу 5.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.


### Төслийн зээл санхүүжилт

2019 оны I улиралд 41 ББСБ 18.1 тэрбум төгрөгийн төслийн зээлтэй байгаа нь нийт хөрөнгийн 1.3 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 10.1% буюу 1.7 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 1.5% буюу 262.2 сая төгрөгөөр өсжээ.

Төслийн санхүүжилтийн 82.9% буюу 15.0 тэрбум төгрөгийг төгрөгийн, 17.1% буюу 3.1 тэрбум төгрөгийг валютын зээл эзэлж байна.



Зураг 16 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат санхүүжилтээр 12 ББСБ 3.7 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байгаа бол урт хугацаат санхүүжилтээр 32 ББСБ 14.4 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна.

Төслийн зээлийн 9.6 тэрбум төгрөгийг гадаад байгууллагаас, 6.4 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас, 1.3 тэрбум төгрөгийг Засгийн газрын төслийн зээлийн эх үүсвэрээс 0.8 тэрбум төгрөгийг бусад санхүүжилтээс бүрдүүлсэн байна.


### Бусад өр төлбөр

2019 оны I улирлын байдлаар 495 ББСБ 57.6 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт пассивын 4.1 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 89.3% буюу 27.2 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 37.7% буюу 15.8 сая төгрөгөөр өссөн дүн байна.

Бусад өр төлбөрийн 80.3% буюу 46.3 тэрбум төгрөгийг бусад пассив, 17.4% буюу 10.0 тэрбум төгрөгийг хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 2.3% буюу 1.3 тэрбум төгрөгийг санхүүгийн үүсмэл хэрэгсэлийн өглөг бүрдүүлж байна.

Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг болон бусад пассивын задаргаа:

Зураг 17 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг



Хүснэгт 14 Бусад пассив /сая төгрөгөөр/

БУСАД ПАССИВ	46,281.4
Салбар хоорондын тооцооны өглөг	7,200.8
Цалингийн өглөг	311.4
Татварын өглөг	7,014.7
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	232.0
Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өглөг	107.9
Ногдол ашгийн өглөг	1,631.6
Бусад өглөг	29,783.0

### 3.2 Эздийн өмч

2019 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт пассивын 76.1 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

ББСБ-уудын өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 250.1 тэрбум төгрөг буюу 30.8 хувиар өссөн байна.

Зураг 18 Пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/

	I улирал					
	2014	2015	2016	2017	2018	2019
Хувьцаат капитал	198.8	262.0	341.3	508.7	645.5	832.4
Бусад өмч	7.3	7.5	11.2	6.5	10.1	16.2
Сангууд	0.3	0.4	0.5	0.6	0.5	0.7
Хуримтлагдсан ашиг	41.9	65.7	101.8	116.5	154.5	211.4
Хоёрдогч өглөг	1.7	1.8	0.8	0.9	0.7	0.8
<b>Нийт пассив</b>	<b>404.8</b>	<b>515.9</b>	<b>634.1</b>	<b>795.8</b>	<b>1,046.8</b>	<b>1,395.5</b>

2019 оны I улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 83 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 41.6 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.4-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 206 ББСБ 38.7 хувийг эзэлж

байгаа бол 1.4 тэрбумаас доош хөрөнгөтэй 250 ББСБ 19.7 хувийг бүрдүүлж байна.

Эдгээр 250 ББСБ-ын 115 ББСБ нь хөдөө орон нутгийн болон гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд байна.


*Хүснэгт 15 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/*

Интервал	ББСБ тоо	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
1.4 тэрбумаас доош	250	46.4%	164.0	19.7%
1.4-1.8 тэрбум хүртэл	170	31.5%	247.7	29.8%
1.9-2.4 тэрбум хүртэл	36	6.7%	74.7	9.0%
2.5-4.9 тэрбум хүртэл	63	11.7%	181.9	21.9%
5 тэрбум ба түүнээс дээш	20	3.7%	164.0	19.7%
<b>НИЙТ</b>	<b>539</b>	<b>100.0%</b>	<b>832.4</b>	<b>100.0%</b>

#### 4. Орлого, үр дүнгийн тайлан

2019 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 75.4 тэрбум төгрөгийн орлоготой, 44.4 тэрбум төгрөгийн зарлагатай 31.0 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.


Зураг 19 Ашигт ажиллагааны үзүүлэлт



##### 4.1 Орлого

2019 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.7% буюу 18.6 тэрбум төгрөгөөр 75.4 тэрбум төгрөгийн орлоготой гарчээ. Хүүгийн орлого 15.7 тэрбум төгрөгөөр, хүүгийн бус орлого 3.0 тэрбум төгрөгөөр өсөж, үндсэн бус үйл ажиллагааны орлого 0.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 20 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/



#### Хүүгийн орлого

Хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар буюу 15.7 тэрбум төгрөгөөр өсөж нийт орлогын 84.1% буюу 63.4 тэрбум төгрөгийн дүнтэй гарсан байна.

472 ББСБ 63.4 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олжээ.

Хүүгийн орлогыг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн 59.9 тэрбум төгрөгийн орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн 3.2 тэрбум төгрөгийн орлого, 277.2 мянган төгрөгийн бусад хүүгийн орлого бүрдүүлж байна.

#### Хүүгийн бус орлого

2019 оны I улирлын байдлаар 373 ББСБ 9.9 тэрбум төгрөгийн хүүгийн бус орлого олсон нь нийт орлогын 13.2 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 44.0% буюу 3.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт байна.

Зураг 21 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/



Гадаад валют арилжааны орлого 0.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1.1 тэрбум төгрөгт хүрч 11.8 хувийн өсөлт үзүүлсэн бол гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого 0.01 тэрбум төгрөгөөр өсөж 1.8 тэрбум төгрөг, санхүүгийн үйлчилгээний орлого 69.6% буюу 2.9 тэрбум төгрөгөөр өсөж 7.1 тэрбум төгрөгт хүрсэн эерэг үр дүн үзүүлсэн байна.

Санхүүгийн үйлчилгээний орлогын өсөлтөд үйлчилгээ хураамж шимтгэлийн орлого 2.2 дахин буюу 2.9 тэрбум төгрөгөөр өсөж 5.4 тэрбум төгрөгт хүрсэн нь нөлөөлсөн байна.

ББСБ-уудын зах зээлд гаргасан финтекд суурилсан хүүгүй зээлийн бүтээгдэхүүний үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого 2.9 тэрбум төгрөгийн өсөлтийн 2.6 тэрбум төгрөгийг буюу 92 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 16 Санхүүгийн үйлчилгээний орлого /мянган төгрөгөөр/

	2018-I	2019-I	Өөрчлөлт
Итгэлцлийн үйлчилгээний орлого	2,283.9	770.7	-66.3%
Мөнгөн гуйвуулгын орлого	330,042.2	230,682.9	-30.1%
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	37,238.0	64,192.5	72.4%
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,499,870.8	5,390,706.1	2.2 дахин
Бусад	1,311,579.6	1,404,031.4	7.0%
<b>НИЙТ</b>	<b>4,181,014.5</b>	<b>7,090,383.6</b>	<b>69.6%</b>

#### Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогын 2.7 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 131.1 сая төгрөгийн буюу 6.0 хувийн бууралттай байна.

Зураг 22 Үндсэн бус үйл ажиллагааны орлого



#### 4.2 Зарлага

2019 оны I улиралд 44.4 тэрбум төгрөгийн зардалтай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.1 хувиар өссөн үзүүлэлт байна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал болон болзошгүй эрсдэлийн зардал буурсан үзүүлэлттэй гарсан бол бусад зардал өссөн дүнтэй гарчээ.

Хүснэгт 17 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2018-I	2019-I	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Хүүгийн зардал	4.6	6.0	1.4	29.4%
Хүүгийн бус зардал	21.3	25.5	4.2	19.8%
Болзошгүй эрсдэлийн зардал	9.3	8.5	(0.7)	-7.9%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.7	0.6	(0.1)	-8.4%
Орлогын албан татварын зардал	2.6	3.7	1.0	39.0%
<b>Нийт зарлага</b>	<b>38.5</b>	<b>44.4</b>	<b>5.8</b>	<b>15.1%</b>

#### Хүүгийн зардал

Хүүгийн зардал нийт зардлын 13.5% буюу 6.0 тэрбум төгрөг байна. Өмнөх оны мөн үеийн дүнтэй харьцуулахад 29.4% буюу 1.4 тэрбумаар өссөн байна.

#### Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардал нь 25.5 тэрбум төгрөг буюу нийт зардлын 57.6 хувийг бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.8% буюу 4.2 тэрбум төгрөгөөр өсжээ.

#### Болзошгүй эрсдэлийн зардал

Нийт зардлын 19.3% буюу 8.5 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал бүрдүүлж байгаа ба энэ зардал нь өмнөх оны мөн үеэс 7.9% буюу 736.8 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарсан байна. Үүнд зээлийн эрсдэлийн зардал 754.3 сая төгрөгөөр, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал 140.4 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

#### Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Нийт зардлын 1.3 хувийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 8.4% буюу 54.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ.


#### 4.3 Ашигт ажиллагаа

2019 оны I улиралд ББСБ-ууд 31.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн

оны мөн үеэс 12.8 тэрбум төгрөгөөр буюу 69.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

539 ББСБ-ын 434 нь буюу 80.5% нь 34.6 тэрбум төгрөгийн ашигтай, 85 нь буюу 15.8% нь 3.6 тэрбум төгрөгийн алдагдалтай, 20 нь буюу 3.7% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Зураг 23 Ашгийн өсөлт /хувиар/




## 5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2019 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 539 ББСБ-ын 88.3% буюу 476 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 11.7% нь буюу 63 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 48 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 11 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 0 ББСБ, 5 ба түүнээс дээш зохистой харьцаа алдагдсан 2 ББСБ байна.

Зураг 24 Зохистой харьцаа



## Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 18 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШУ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	42	91.3%
1 зохистой харьцааг хангаагүй	1	2.2%
2 зохистой харьцааг хангаагүй	3	6.5%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
<b>НИЙТ</b>	<b>46</b>	<b>100%</b>

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 43 ББСБ хангасан буюу биелэлт 93.5%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 43 ББСБ хангасан буюу биелэлт 93.5%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн хангасан;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн хангасан;
5. Үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлагыг 45 ББСБ хангасан буюу 97.8%;
6. Өөрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Эдгээр 46 ББСБ-уудын хувьд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас

доошгүй байх шалгуур үзүүлэлт хамгийн ихээр алдагдсан байна.

### Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 19 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШУ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	409	88.5%
1 зохистой харьцааг хангаагүй	42	9.1%
2 зохистой харьцааг хангаагүй	7	1.5%
3 зохистой харьцааг хангаагүй	2	0.4%
4 зохистой харьцааг хангаагүй	0	0.0%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	2	0.4%
<b>НИЙТ</b>	<b>462</b>	<b>100%</b>

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 456 ББСБ хангасан буюу биелэлт 98.7%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 455 ББСБ хангасан буюу биелэлт 98.5%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 460 ББСБ хангасан буюу биелэлт 99.6%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 446 ББСБ хангасан буюу биелэлт 96.5 хувь;
5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний зөрүү 0 байх шаардлагыг 461 ББСБ хангасан буюу биелэлт 99.8%;
6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 454 ББСБ хангасан буюу биелэлт 98.3%;

7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 456 ББСБ хангасан буюу биелэлт 98.7%;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 460 ББСБ хангасан буюу биелэлт 99.6%;
9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
10. Нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
11. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
12. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага 453 ББСБ хангасан буюу биелэлт 98.1%;
13. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 447 ББСБ хангасан буюу биелэлт 96.8% хувь;
14. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх 462 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 16 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 15 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

### Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.4-т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 20 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШУ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	25	80.6%
1 зохистой харьцааг хангаагүй	5	16.1%
2 зохистой харьцааг хангаагүй	1	3.2%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
<b>НИЙТ</b>	<b>31</b>	<b>100%</b>

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 26 ББСБ хангасан буюу биелэлт 83.9%;
5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 31 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 10 хувиас ихгүй байх шаардлагыг 31 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас ихгүй

байх шаардлагыг 31 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;

10. Худалдан авах хувьцааны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
11. Нэг компаниас худалдан авах хувьцааны төвлөрлийн үзүүлэлт өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
12. Өрийн бичгийн эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлагыг 31 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
14. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
15. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
16. Итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
17. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг шаардлагыг 29 ББСБ хангасан буюу биелэлт 93.5%;
18. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй айх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх 31 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 5 ББСБ, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 2 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

## 6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд

#### Ерөнхий статистик

Тайлант онд хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 77 ББСБ, 182 хувьцаа эзэмшигч, 189 ажилтан, 4 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 8090 харилцагч, 7773 зээлдэгчдэд хүрч ажиллаж байна.

Хамгийн олон ББСБ-тай аймгууд нь Төв аймаг 10, Орхон, Дорнод аймгуудад тус тус 7 ББСБ байршиж байна.

Зураг 25 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт



Хүснэгт 21 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны төрөл	ББСБ тоо
1	Зээл	74
2	Гадаад валютын арилжаа	6
3	ХОСЧЗМӨ	1
4	Итгэлцлийн үйлчилгээ	1
<b>НИЙТ</b>		<b>82</b>

Хөдөө орон нутгийн ББСБ-ууд 4 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 82 үйл ажиллагаа эрхэлж байна. 35 ББСБ буюу 45.4% нь санхүүгийн програмтай байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 90.1% буюу 7006 нь хэвийн, 4.7% буюу 363 нь хугацаа хэтэрсэн, 5.2% буюу 404 нь чанаргүй зээлдэгчид байна.

ББСБ-уудын зээлдэгчдийн насжилтаар авч үзвэл хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 75.7 хувийг 18-45 насны,

17.6 хувийг 46-55 насны, 6.7 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлж байна. Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой иргэд 51.6%, тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой иргэд 40.1%, бага болон дунд боловсролтой иргэд 8.2 хувийг бүрдүүлж байна.

#### Актив

Салбарын нийт активын 2.6 хувийг бүрдүүлж байгаа орон нутгийн ББСБ-уудын 36.0 тэрбум төгрөгийн актив хөрөнгийн 7.4 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 163.2 сая төгрөг нь богино хугацаат хөрөнгө оруулалт цэврээр/, 24.7 тэрбум нь зээл /цэврээр/, 245.1 тэрбум төгрөг нь өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр), 2.7 тэрбум төгрөгийг бусад хөрөнгө, 937.8 сая




төгрөг нь үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр) бүрдүүлж байна.

Хүснэгт 22 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	35,109,582.1	97.4%
Мөнгөн хөрөнгө	7,368,951.6	20.4%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	163,205.9	0.5%
Зээл (цэврээр)	24,671,713.9	68.4%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	245,108.1	0.7%
Бусад хөрөнгө	2,660,602.6	7.4%
Эргэлтийн бус хөрөнгө	937,808.9	2.6%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	937,808.9	2.6%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>36,047,391.0</b>	<b>100.0%</b>

Нийт зээлийн 78.7% буюу 23.3 тэрбум төгрөгийн хэвийн зээл, 3.7% буюу 1.1 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 17.6% буюу 5.2 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Зээлийн эрсдэлийн санг хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээлийн 79.0 хувьд байгуулжээ.

Зураг 26 Орон нутгийн ББСБ-уудын чанаргүй зээлийн бүтэц



2019 оны I улиралд хөдөө орон нутгийн банк санхүүгийн байгууллагын 1.3 тэрбум төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгөд 396.8 сая төгрөгийн элэгдэлийн сан байгуулж, 937.8 сая төгрөгийн цэвэр үндсэн ба биет бус хөрөнгө бүртгэгдсэн байна.

### Пассив

Хөдөө орон нутгийн 77 ББСБ-ын хөрөнгө 36.0 тэрбум төгрөгийн 91.6% буюу 33.0 тэрбум төгрөг нь эздийн өмч, 8.4% буюу 3.0 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. Хөдөө орон нутгийн ББСБ-уудын нийт

хөрөнгийн 84.2 хувийг буюу 30.3 тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлж байгаа ба энэ нь салбарын хувьцаат капиталын 3.1 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 23 Орон нутгийн ББСБ-уудын пассивын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум.төг/	Дүн	Хувь
Өр төлбөр	3.0	8.4%
Санхүүгийн эх үүсвэр	0.9	2.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	0.3	0.7%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.1	0.4%
Төслийн зээлийн санхүүжилт	0.7	1.9%
Бусад өр төлбөр	1.1	3.0%
Эздийн өмч	33.0	91.6%
Хувьцаат капитал	30.3	84.2%
Бусад өмч	0.8	2.1%
Сангууд	0.6	1.6%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	1.3	3.7%
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>36.0</b>	<b>100.0%</b>

### Орлого үр дүнгийн тайлан

2019 оны I улиралд хөдөө орон нутгийн ББСБ-ууд 2.1 тэрбум төгрөгийн орлоготой, 1.3 тэрбум төгрөгийн зарлагатай, 775.6 сая төгрөгийн цэвэр орлоготой ажиллаа. Орлогын 89.5% буюу 1.8 тэрбум төгрөгийг хугацаандаа байгаа хүүгийн орлого бүрдүүлж байна. Нийт зардлын 68.9% буюу 893.4 сая төгрөгийг хүүгийн бус зардал, 19.4% буюу 251.7 сая төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал эзэлж байна.

### 6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд

#### Ерөнхий статистик

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай, 11 улсын 38 хувьцаа эзэмшигчийн 28 ББСБ, 8 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 53 үйл ажиллагаа явуулж байгаа нь салбарын ББСБ-ын тооны 5.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 24 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрөл	ББСБ-ын тоо
Зээл	27
Факторингийн үйлчилгээ	2
Төлбөрийн баталгаа гаргах	5
Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	1
Гадаад валютын арилжаа	9
Итгэлцлийн үйлчилгээ	3
Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	4
<b>НИЙТ</b>	<b>53</b>

### Актив

Гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ-ын хөрөнгө 185.7 тэрбум төгрөг нь нийт хөрөнгийн 13.3 хувийг бүрдүүлж байна.

Активын 84.7% буюу 157.4 тэрбум төгрөг нь зээл, 9.0% буюу 16.7 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байгаа бол мөнгөн хөрөнгийн 23.8% буюу 4.0 тэрбум төгрөг нь кассанд, 47.5% буюу 7.9 тэрбум төгрөг нь харилцах дансанд, 28.6% буюу 4.3 тэрбум төгрөг нь хадгаламжийн дансанд тус тус байршиж байна.

### Пассив

Пассивын 50.8% буюу 94.3 тэрбум төгрөгийг өр төлбөр, 49.2% буюу 91.4 тэрбум төгрөгийг эздийн өмч эзэлж байна.

Нийт 539 ББСБ-ын пассивын бүтэц нь эздийн өмч давамгайлсан бүтэцтэй байдаг бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд өр төлбөр болон эздийн өмчийн дүн ойролцоо дүнтэй байна. Өр төлбөрийн 55.7% нь дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл байгаа бол эздийн өмчийн 86.5% нь хувьцаат капитал байна.

Хүснэгт 25 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	Дүн	Хувь
Өр төлбөр	94.3	50.8%
Санхүүгийн эх үүсвэр	21.8	11.7%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	52.6	28.3%
Бусад эх үүсвэр	1.0	0.5%
Төслийн зээлийн санхүүжилт	8.3	4.5%
Бусад өр төлбөр	10.7	5.8%

Эздийн өмч	91.4	49.2%
Хувьцаат капитал	79.0	42.6%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	11.2	6.0%
Эздийн өмчийн бусад хэсэг	1.1	0.6%
<b>НИЙТ ПАССИВ</b>	<b>185.7</b>	<b>100.0%</b>

Дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн 73.9% буюу 109.7 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагуудаас, 26.1% буюу 38.7 тэрбум төгрөгийг гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас авсан өр төлбөр эзэлж байна.

### Орлого үр дүнгийн тайлан

Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд 11.7 тэрбум төгрөгийн орлоготой, 7.7 тэрбум төгрөгийн зарлагатай, 4.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

### 6.3 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд

#### Ерөнхий статистик

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа /+ЦТТМГ 2 ББСБ/ 46 ББСБ нь нийт ББСБ-уудын 8.5%, гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудын 29.7% буюу 46 ББСБ, 6 салбар, 126 ажилтан, 20,674 харилцагчдад хүрч үйл ажиллагаа эрхэлж байна.

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 155 ББСБ байгаагаас дагнан эрхэлж байгаа 46 ББСБ-уудын 43 нь Улаанбаатар хотод, 3 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

#### Актив

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын нийт активын хэмжээ 10.9 тэрбум төгрөг байгаа нь салбарын активын 0.8% байна. Нийт активын 96.9% нь мөнгөн хөрөнгө, 0.01% нь богино хугацаат хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 26 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	10,670,955.3	98.1%
Мөнгөн хөрөнгө	10,531,812.2	96.9%

Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,000.0	0.0%
Бусад хөрөнгө	138,143.1	1.3%
Эргэлтийн бус хөрөнгө	201,727.5	1.9%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	201,727.5	1.9%
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>10,872,682.9</b>	<b>100.0%</b>

### Пассив

Нийт хөрөнгийн 92.0% буюу 10.0 тэрбум төгрөг нь хувьцаат капитал, 6.6% буюу 719.6 сая төгрөг нь хуримтлагдсан ашиг, 1.1% буюу 118.5 сая төгрөг нь өр төлбөр, 0.3% буюу 29.7 сая төгрөг нь бусад өмч байна.

*Хүснэгт 27 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /мянган төгрөгөөр/*

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Өр төлбөр	118,511.30	1.1%
Хувьцаат капитал	10,004,862.40	92.0%
Бусад өмч	29,747.70	0.3%
Хуримтлагдсан ашиг	719,561.46	6.6%
<b>Нийт пассив</b>	<b>10,872,682.86</b>	<b>100%</b>

### Орлого үр дүнгийн тайлан

Тайлант хугацаанд 290.9 сая төгрөгийн орлоготой, 283.4 сая төгрөгийн зарлагатай, 7.5 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

39 ББСБ 290.9 сая төгрөгийн орлоготой, 5 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.

### Гадаад валютын арилжааны дүн мэдээ

Хорооны гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 155 ББСБ-уудын 2019 оны 1 сараас 2019 оны 3 сар хүртэлх арилжааны дүн мэдээгээр 198.2 тэрбум төгрөгийн гадаад валют худалдан авч 188.1 тэрбум төгрөгийн гадаад валют зарсан байна.

*Хүснэгт 28 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн мэдээ /2019-I улирал/*

ББСБ-ын валют арилжааны дүн	Худалдаж авсан 198,246,247,450.17	Зарсан 188,136,956,911.29
АНУ-ын доллар	87,408,857,013.96	79,919,235,730.36
БНХАУ-ын юань	73,111,214,840.65	71,469,126,454.50
Евро	21,895,463,446.20	21,327,057,746.18
БНСУ-ын вон	5,575,958,985.65	5,549,235,266.25
Японы иен	4,711,633,273.86	4,645,855,010.21
ОХУ-ын рубль	3,314,825,145.04	3,257,123,944.72
Английн фунт	774,217,008.77	719,130,305.78
Хонконг доллар	600,361,598.50	524,452,021.86
Швейцарь франк	279,430,978.10	215,658,126.41
Австралийн доллар	224,485,361.78	199,284,351.30
Сингапурын доллар	174,904,906.26	139,900,539.06
БНАСАУ-ын вон	60,740,228.95	60,900,319.50
Канадын доллар	49,790,773.00	41,987,415.00
Шведийн крон	46,889,903.46	49,790,984.97
Тайланд бат	13,965,600.00	13,789,795.20
Энэтхэгийн рупи	3,508,386.00	4,428,900.00

## ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс:  
2019 оны I улиралд 369 ББСБ 761.1 сая төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.
- Зээлийн мэдээллийн сан:  
Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 493 ББСБ-ын 96.6% буюу 476 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх:  
2019 оны I улиралд Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 539 ББСБ-ын 52.3 хувь буюу 282 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 261 ББСБ хэрэгжүүлсэн байх тул Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.4 дэх хэсгийн “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
- 20 сая төгрөгөөс дээш гүйлгээг мэдээлэх:  
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд нэр бүхий 154 ББСБ, 3,609 удаагийн тохиолдлоор, 329.1 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

## ДҮГНЭЛТ

2019 оны I улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 539 ББСБ-аас 96.5% буюу 520 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд 19 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2019 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 7207 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ 220 салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2820 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,664,902 харилцагчдад хүрч үйлчилж байна. Улаанбаатар хотод 462 ББСБ, 152 салбар, хөдөө орон нутагт 77 ББСБ, 68 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2019 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.4 их наяд төгрөг байгаа нь банкны салбарын 4.2%-тай тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад актив 348.7 тэрбум төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн байна. Активын өсөлтийн 77.1 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 53.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 1.4 тэрбумаас дээш хөрөнгөтэй 313 ББСБ нийт активын 88.7 хувийг, 1.0-1.4 тэрбум хүртэл хөрөнгөтэй 106 ББСБ нийт активын 8.7 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 119 ББСБ нийт активын 2.6 хувийг эзэлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 975.5 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 5.6 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 846.2 тэрбум төгрөг буюу 86.7 хувийг хэвийн зээл, 40.2 тэрбум төгрөг буюу 4.1 хувийг хугацаа хэтэрсэн

зээл, 10.8 тэрбум төгрөг буюу 9.1 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдлийн 52.9 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна. Өмнөх оны мөн үеэс хэвийн зээл 43.3 хувиар буюу 255.7 тэрбум төгрөгөөр, хугацаа хэтэрсэн зээл 6.0% буюу 2.3 тэрбум төгрөгөөр, чанаргүй зээлийн хэмжээ 13.9 хувиар буюу 10.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 493 ББСБ-аас 298 ББСБ 431.9 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 3.4%-тай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй гарсан байна. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 2.0 пунктээр өндөр байна.

Салбарын нийт хөрөнгийн 23.9% буюу 334.1 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 76.1% буюу 1,061.4 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. Харин өр төлбөрийн 44.5% буюу 148.5 тэрбум төгрөгийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, 19.8% буюу 66.1 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээний өглөг эзэлж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн 78.4% буюу 832.4 тэрбум төгрөгийг хувьцаат капитал, 19.9% буюу 211.4 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг эзэлж байна.

2019 оны I улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 83 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 41.6 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.4-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 206 ББСБ 38.7 хувийг эзэлж байгаа бол 1.4 тэрбумаас доош хөрөнгөтэй 250 ББСБ 19.7 хувийг бүрдүүлж байна. Эдгээр 250 ББСБ-ын 115 ББСБ нь хөдөө орон нутгийн болон гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд байна.

2019 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 539 ББСБ-ын 88.3% буюу 476 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан бол 11.7% нь буюу 63 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна.

## **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**